



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
Е-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД**

2020.07.30 № 82  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Дундговь аймгийн Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

***Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл***

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Дундговь аймгийн Монгол ардын намын хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

***Дүгнэлтийн үндэслэл***


Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Дундговь аймгийн Монгол ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

0012020388

*Дүгнэлт*

**ДУНДГОВЬ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО** нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

МАЯГТ-2

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд “Аж ахуйн нэгж”-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

Дундговь аймгийн Монгол ардын нам

/МЯН.ТӨГ/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл			Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг			Утасны дугаар	Банкны нэр	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон									
1	Х	Х				Х			
2	Х	Х				Х			
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд									
1	Х	Х				Х			
2	Х	Х				Х			
8									

\* Дээрх хүснэгтийн дутуу мэдээллүүдийг гүйцээж, тайлбар хэсэгт юунд зориулсан хандивыг тодорхой бичнэ.

Хянасан: Сангийн хөрөнгийн дарга

Боловсруулсан: Нягтлан бодогч



/ О.Бат-Эрдэнэ /

/ Т.Отгондулам /

МАЯГТ-1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох  
нам, эвсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

Дундговь аймгийн Монгол ардын нам

/МЯН.ТӨГ/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл			Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг			Утасны дугаар	Банкны нэр	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон									
1	Х	Х				Х		Х	
2	Х	Х				Х		Х	
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд									
1	Х	Х				Х		Х	
2	Х	Х				Х		Х	
8									

\* Дээрх хүснэгтийн дутуу мэдээллүүдийг гүйцээж, тайлбар хэсэгт юунд зориулсан хандивыг тодорхой бичнэ.

Хянасан: Сангийн хөрөнгийн дарга

Боловсруулсан: Нягтлан бодогч

/ О.Бат-Эрдэнэ /

/ Т.Отгондулам /

